

АЧААНЫ ДАГАЛДАХ БИЧИГ

Илгээгчийн нэр, хаяг:			Дагалдах бичиг үйлдсэн огноо		Дугаар		
Тээвэрлэгчийн нэр, хаяг:			Хүлээн авагчийн нэр, хаяг:				
Ачааг ачих газар:			Ачааг хүргэх газар:				
Ачааг тээвэрлэгчид шилжүүлэх он, сар, өдөр:			Ачааг хүргэх хугацаа:				
Тээврийн хэрэгслийн марк, төрөл, улсын дугаар:							
Ачааны нэр	Ачааны төрөл	Хэмжих нэгж	Ачааны тоо хэмжээ		Сав, баглаа, боодлын төрөл	Бүх жингийн талаарх тэмдэглэл	Овор хэмжээний талаарх тэмдэглэл
			Илгээсэн	Хүлээн авсан			
Ачааны онцлогтой холбоотой нэмэлт нөхцөл, шаардлага							
Тээврийн хөлсний тооцоо:					Тарифын тухай тэмдэглэл		
Явуулах үед:		Тээврийн хөлс					
		Бүгд хураасан					
Олгох үед:		Тээврийн хөлс			Ачааг даатгалд хамруулах эсэх		
		Бүгд хураасан					
Тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хооронд тохиролцсон нэмэгдэл нөхцөл:							
Тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн баримт бичгийн жагсаалт:							
Ачааг тээвэрлэлтийн гэрээнээс гадна автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх нийтлэг дүрэм, тухайн төрлийн ачааг тээвэрлэхтэй холбоотой журам, стандартын дагуу гүйцэтгэнэ.							
Илгээгчийн гарын үсэг, он, сар, өдөр:			Тээвэрлэгчийн гарын үсэг, он, сар, өдөр:			Хүлээн авагчийн гарын үсэг, он, сар, өдөр:	
Тээврийн хяналтын цэгүүдийн тэмдэглэл:							

"Тээвэрлэлттэй холбогдсон баримт бичгийг хэвлүүлэх ашиглах журам"-ын дагуу хувиран ашиглахыг хориглоно.

Улс хооронд ачаа тээвэрлэх тохиолдолд олон улсын ачааны дагалдах хуудсыг хэрэглэнэ.

АЧААНЫ ДАГАЛДАХ БИЧГИЙГ БӨГЛӨХ ЗААВАР

Ачаа тээврийн дагалдах бичгийг дараах зааврын дагуу бөглөнө.

1. **Илгээгчийн нэр, хаяг** гэсэн нүдэнд ачааг илгээж байгаа аж ахуйн нэгж байгууллагын нэр, хаягийг бичнэ. /Ачаа илгээгч нь иргэн бол илгээгчийн овог нэр, хаягийг бичнэ/
2. **Дагалдах бичиг үйлдсэн огноо** гэсэн нүдэнд тухайн бичгийг үйлдсэн он, сар өдрийг бичнэ.
3. **Дугаар** гэсэн нүдэнд тухайн ачааны дагалдах бичиг нь тээвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дагалдах хуудаст өгөх дугаарлалтыг бичнэ.
4. **Тээвэрлэгчийн нэр, хаяг** гэсэн нүдэнд тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээр байгаа нэр, хаягийг, иргэн бол овог нэр, өөрийн бүртгэлтэй хаягийг бичнэ.
5. **Хүлээн авагчийн нэр, хаяг** гэсэн нүдэнд хүлээн авагч аж ахуйн нэгж байгууллагын нэр, хаяг утасны дугаарыг, иргэн бол хүлээн авах иргэний овог нэр, хаяг, утасны дугаарыг бичнэ.
6. **Ачаа ачих газар** гэсэн нүдэнд тухайн ачааг ачсан газрын нэрийг бичнэ.
7. **Ачааг хүргэх газар** гэсэн нүдэнд ачаа хүлээн авагчийн ачаа хүлээн авах газрыг бичнэ.
8. **Ачааг тээвэрлэгчид шилжүүлэх он, сар, өдөр** гэсэн нүдэнд ачаа илгээгчийн тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн он, сар, өдрийг бичнэ.
9. **Ачааг хүргэх хугацаа** гэсэн нүдэнд ачааг хүлээн авагчид хүлээлгэн өгөх он, сар, өдрийг тэмдэглэнэ.
10. **Тээврийн хэрэгслийн марк, төрөл, улсын дугаар** гэсэн нүдэнд тухайн ачааг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн марк, төрөл, улсын дугаарыг бичнэ.
11. **Ачааны нэр** гэсэн нүдэнд тухайн тээвэрлэж буй ачааны нэрийг бичнэ
12. **Ачааны төрөл** гэсэн нүдэнд Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ MNS 5346:2003 стандартын 4.3-ын б/ хэсэгт заасан төрлөөр ангилан бичнэ. /жишээ нь. Аж үйлдвэрийн өргөн хэрэглээний, хүнсний өргөн хэрэглээний, хөдөө аж ахуйн, барилгын материал гэх мэт/
13. **Хэмжих нэгж** гэсэн хэсэгт тухайн ачааны жингийн хэмжээг килограммаар эсвэл тонноор бичнэ.
14. **Ачааны тоо хэмжээ** гэсэн нүдэнд тухайн ачаа нь хэдэн ширхэг, сав, баглаа, боодол ачаа тээвэрлэж байгааг бичнэ.
Илгээсэн гэсэн хэсэгт ачаа илгээгчийн илгээсэн тоо хэмжээг, хүлээн авсан гэсэн нүдэнд хүлээн авагч хэдийг хүлээн авсан тоо хэмжээгээ бичнэ.
15. **Сав, баглаа, боодлын төрөл** гэсэн нүдэнд тухайн илгээж байгаа ачааны сав, баглаа, боодлын төрлийг бичнэ. / шуудай, хайрцаг гэх мэт/
16. **Бүх жингийн талаарх тэмдэглэл** гэсэн нүдэнд нийт илгээсэн ачааны жинг бичнэ. Ачаа тус бүрийн жингийн нийлбэрээр тооцно.
17. **Овор хэмжээний талаарх тэмдэглэл** гэсэн нүдэнд тухайн ачааны урт, өндөр, өргөний хэмжээг тэмдэглэнэ.
18. **Ачааны онцлогтой холбоотой нэмэлт, нөхцөл, шаардлага** гэсэн нүдэнд тухайн ачааны тээвэрлэлтийн онцлогтой холбоотой нэмэлт нөхцөл шаардлагыг бичнэ. Тухайлбал аюултай, овор ихтэй, хүнсний түргэн муудах гэх мэт ачаа тээвэрлэх тохиолдолд ачаа илгээгчээс тавих нэмэлт шаардлага, тээвэрлэлтийн онцлогийг бичнэ.
19. **Тээврийн хөлсний тооцооны явуулах үед** гэсэн нүдэнд ачаа илгээгчийн төлсөн төлбөр, тооцооны хэмжээг, олгох үед гэсэн хэсэгт ачаа хүлээн авагчийн төлсөн төлбөр тооцооны тэмдэглэгээг хийнэ.
20. **Тарифын тухай тэмдэглэл** гэсэн нүдэнд нэг килограмм ачааг тээвэрлэх тээврийн хөлсний хэмжээг бичнэ.
21. **Ачааг даатгалд хамруулах эсэх** гэсэн нүдэнд ачаа илгээгч ачаагаа даатгалд хамруулсан тохиолдолд тэмдэглэгээ хийнэ.
22. **Тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хооронд тохиролцсон нэмэгдэл нөхцөл** гэсэн нүдэнд ачааг тээвэрлэхтэй холбоотой тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хооронд тохирсон анхаарах ёстой нэмэлт нөхцлүүдийг бичнэ.
23. **Тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн баримт бичгийн жагсаалт** гэсэн нүдэнд ачааг тээвэрлэх, хүлээлгэн өгөх үед шаардлагатай баримт бичгүүдийг ойлгоно. /ачааны гарал үүсэл, хорио цээр, холбогдох зөвшөөрөл гэх мэт бичиг баримтууд хамаарна./
24. **Илгээгчийн гарын үсэг, он, сар, өдөр** гэсэн нүдэнд ачаа илгээгчийн гарын үсэг, ачааг тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн он, сар, өдрийг бичнэ.
25. **Тээвэрлэгчийн гарын үсэг, он, сар, өдөр** гэсэн нүдэнд тээвэрлэгчийн гарын үсэг, ачааг тээвэрлэлтэд хүлээн авсан он, сар, өдрийг бичнэ.
26. **Хүлээн авагчийн гарын үсэг, он, сар, өдөр** гэсэн нүдэнд ачаа хүлээн авагчийн гарын үсэг, ачааг тээвэрлэгчээс хүлээн авсан он, сар, өдрийг бичнэ.
27. **Тээврийн хяналтын цэгүүдийн тэмдэглэл** гэсэн нүдэнд ачааг хүлээн авагчид хүргэх зам дагуух хяналтын цэгүүдэд тэмдэглэгээг хийлгэнэ.